210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	626.55	46.30
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	703.10	515.80
210815	Хүүний төлбөрт төлсөн /ТӨҮГ/	7,352.10	665.54
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	1,374,355.84	1,072,692.81
210817	Даатгалын төлбөрт төлсөн /ТӨҮГ/	14,474.56	13,988.50
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	1,898,778.35	2,193,976.88
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>19,973,961.79</b>	<b>9,060,988.63</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,862,120.44	9,026,575.23
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	111,841.35	34,413.40
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,872,840.89</b>	<b>1,486,584.46</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	-	1,025,248.06
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	1,025,248.06
213101	Бусад засгийн газрын дотоод шилжүүлэг		1,025,248.06
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,872,840.89</b>	<b>461,336.40</b>
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	151,696.74	58,491.80
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	108,136.80	68,285.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	538,083.84	247,141.10
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,038,412.20	67,860.90

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд  
хийсэн аудитын тайлан

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	36,511.31	19,557.60
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>30,345,139.43</u></b>	<b><u>30,557,914.12</u></b>
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	-	<b>8,197.36</b>
140007	Хүлээн авсан хүүний орлого		8,197.36
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>30,236,568.94</b>	<b>31,961,465.82</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>30,236,568.94</b>	<b>31,961,465.82</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	30,236,568.94	31,961,465.82
220001	Барилга байгууламж	3,123,700.15	3,017,083.74
221001	Их засвар	2,720,313.33	4,793,638.43
222001	Тоног төхөөрөмж	1,030,155.86	1,056,376.27
223001	Бусад хөрөнгө	12,979,352.35	6,053,898.57
225103	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	8,970,400.01	16,580,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,412,647.25	460,468.81
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(30,236,568.94)</u></b>	<b><u>(31,953,268.46)</u></b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>14</b>	<b>Бусад эх үүсвэр</b>	-	-
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх		
145005	Дамжуулан зээлдүүлэх зээлээс эргэж төлөгдөх		
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>172,252.23</b>	-
230001	Эргэж төлөгдөх зээл	172,252.23	
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>(172,252.23)</u></b>	<b>≡</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(63,681.74)</b>	<b>(1,395,354.34)</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	9,334,402.20	9,270,720.47
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	9,270,720.47	7,875,366.13

### 3. АУДИТЫН ТАЙЛАН

#### 3.1 Үндсэн мэдээлэл

##### 3.1.1 Аудит хийсэн үндэслэл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 20 дугаар зүйлийн 20.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасныг тус тус үндэслэн Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

##### 3.1.2 Аудитын зорилт хамрах хүрээ

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг УСНББОУС, СТОУС, санхүүгийн тайлагналын үзэл баримтлалд нийцүүлэн үнэн зөв илэрхийлсэн эсэхэд

дүгнэлт гаргаж, үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэсэн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгуудад Аудитын олон улсын стандарт, Төрийн аудит MNS 6817-4:2020 санхүүгийн аудитын зарчимд заасны дагуу аудитын горим, сорилыг төлөвлөж, хэрэгжүүлсэн.

Төрийн аудитын газар нь Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, дүгнэлт гаргахын өмнө Төрийн аудитын тухай хууль болон Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн захирагчид, орон нутгийн тусгай сангууд, орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн 2025 оны санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан болно.

### **3.1.3 Аудитын арга зүй**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, зарчмыг үнэлж, санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүдийг үндсэн шалгуур болгон хяналтын сорил, шинжилгээний горим гүйцэтгэж, түүврээр ажил гүйлгээ, тооцооллыг давтан шалгаж үнэлгээ өгөв.

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх аудитад баримтлах ерөнхий чиглэл, мөн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж болон бусад эрх зүйн актын хэрэгжилт, тэдгээрийн нийцэл зэрэг асуудлуудыг тусгайлан авч үзэж, үр дүнг тайланд тусгасан.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл, аудитор Б.Үүрийнтуяа, М.Айнур, Ж.Назгүл, Х.Еркебулан нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер, дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Женисбек хэрэгжүүлсэн.

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг 2026 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн 764/8 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.1.4 Материаллаг байдлын түвшин**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн байгууллага, төрийн сан, орон нутгийн тусгай сан, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайланг нэгтгэсэн тул материаллаг байдлын түвшнийг төлөвлөлтийн үе шатанд Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардал 76,189.0 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 761.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 533.3 сая төгрөгөөр тогтоосон. Аудитын явцад материаллаг байдлыг дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт зардал 11,985.0 сая төгрөгөөр нэмэгдсэн тул гүйцэтгэх шатанд материаллаг байдлыг санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 88,174.0 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 899.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 629.3 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

## **3.2 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ НЭГТГЭХЭД БАРИМТАЛСАН АРГАЧЛАЛ, ЗАРЧИМ**

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

Аймгийн Засаг дарга Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2, 54.4 дэх заалтын дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэн, хуулийн хугацаанд Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан байгууллагуудын хоорондын өр төлбөр, авлага, ажил гүйлгээний давхардсан дүнг төвлөрүүлэн захирагчийн тайлангаар 29,425.4 сая төгрөгөөр, ерөнхийлөн захирагчийн тайлангаар 105,815.4 сая төгрөгөөр нийт 135,240.9 сая төгрөгөөр тус тус устгах бичилт хийсэн. Устгах бичилтийн дүнг байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн тайланд харуулсан байна.
- Төсвийн байгууллага, орон нутгийн тусгай сан, төрийн сан, орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээд гэсэн төрлөөр ангилан тайлагнасан байна.
- Засгийн газрын 2025 оны 37 дугаар тогтоолыг үндэслэн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын жагсаалтад Архивын хэлтсийг нэмж аймгийн Засаг даргын 2025 оны А/121 дүгээр захирамжаар бүтэц орон тоог шинэчлэн баталсан байна.

### 3.2.1 Тайланг илэрхийлсэн мөнгөн нэгж

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлжээ.

### 3.2.2 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн яамны [finperform.mof.gov.mn](http://finperform.mof.gov.mn) программаар нэгтгэн гаргасан бөгөөд дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна.

А. Үндсэн тайлан	Б. Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн	В. Санхүүгийн
Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан тодруулгууд	НББ-ийн бодлого, зарчим 3-20 дугаар
Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	1а, 1б, 2а, 2б
Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	Байгууллагын төрлөөрх нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	
Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	Байгууллагын төрлөөрх нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	

Аймгийн ТЭЗ-ийн санхүүгийн тайлан, тодруулгын бүрэлдэхүүн, иж бүрдлийг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1, 54.2, 54.3, 54.4-т заасан шаардлагын дагуу хангаж, ирүүлсэн.

## 3.3 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТАЛААР

### 3.3.1 Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт хөрөнгө болон өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн 154,846.2 сая төгрөг болж, өмнөх оноос 10,670.1 сая төгрөгөөр буюу 7.4 хувиар нэмэгдсэн байна.

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

Хүснэгт №1. Нийт хөрөнгө ба нийт өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч

Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Эргэлтийн хөрөнгийн дүн	18,813.60	20,258.10	1,444.50	13.1
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	125,362.50	134,588.10	9,225.60	86.9
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>144,176.10</b>	<b>154,846.20</b>	<b>10,670.10</b>	<b>100</b>
Нийт өр төлбөр	9,297.40	12,960.60	3,663.20	8.4
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	134,878.70	141,885.60	7,006.90	91.6
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>144,176.10</b>	<b>154,846.20</b>	<b>10,670.10</b>	<b>100</b>

Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, нөөцийн бараа, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данснуудад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Нийт хөрөнгө өмнөх оноос 10,670.1 сая төгрөгөөр өсөхөд тайлант онд УТХО болон ОНХО, аймаг, сумын ОНХС-гийн санхүүжилтээр бэлтгэгдсэн хөрөнгө нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

### 3.3.2 Санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны нийт үр дүн -2,458.7 сая төгрөг гарсан байна. Үүнд:

Төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүн -671.3 сая төгрөгийн, төрийн сангийн үйл ажиллагааны үр дүн -694.6 сая төгрөгийн, төсөл сангийн үйл ажиллагааны үр дүн -918.5 сая төгрөгийн, орон нутгийн өмчит хуулийн этгээд -174.3 сая төгрөгийн үр дүнтэй гарсан байна.

### 3.3.3 Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлангаар Засгийн газрын хувь оролцоо 9,070.0 сая төгрөгөөр өсөж, хуримтлагдсан үр дүн 2,032.6 сая төгрөгөөр буурсан байна.

### 3.3.4 Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайланд мөнгөн орлого 99,174.4 сая төгрөг, зарлага 68,600.5 сая төгрөг байна.

## 4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 4.1 МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 7,875.3 сая төгрөг болж, өмнөх оноос 1,395.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2. Мөнгөн хөрөнгө дансны ангилал, байгууллагын төрлөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Кассад байгаа бэлэн мөнгө	13.8	0	(13.80)	0

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

Банканд байгаа бэлэн мөнгө	9,256.90	7,875.37	(1,381.53)	100
<b>Дүн</b>	<b>9,270.70</b>	<b>7,875.37</b>	<b>(1395.33)</b>	<b>100</b>
Үүнээс, байгууллагын төрлөөр				
Төсөвт байгууллага	3,986.60	4,488.20	501.60	57
Төсөл/ сан	735.70	542.61	(193.09)	6.9
Төрийн сан	2,802.70	2,111.04	(691.66)	26.8
ТӨҮГ болон ОНӨҮГ	1,745.70	733.52	(1,012.18)	9.30
<b>Дүн</b>	<b>9,270.70</b>	<b>7,875.37</b>	<b>(1,395.33)</b>	<b>100</b>

*Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ТЭЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь оны эцэст төсөвт байгууллагын дансны үлдэгдэл 501.6 сая төгрөгөөр өсөж, төсөл сангийн үлдэгдэл 193.0 сая төгрөгөөр, төрийн сангийн дансны үлдэгдэл 691.7 сая төгрөгөөр, аж ахуй нэгжийн дансны үлдэгдэл 1,012.2 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Оны эцсийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 7,875.3 сая төгрөг нь банканд байгаа бэлэн мөнгө бөгөөд гадаад валютаар байршсан мөнгөн хөрөнгө байхгүй байна.

Мөнгөн хөрөнгийн банканд байгаа 7,875.3 сая төгрөгийн үлдэгдлийн 7,141.8 сая төгрөг нь төрийн сангийн үлдэгдэл, 733.5 сая төгрөг нь арилжааны банкны үлдэгдэл байна. Үүнээс 4,488.2 сая төгрөг нь төсөвт байгууллагын, 542.6 сая төгрөг нь төсөл сангийн, 2,111.0 сая төгрөг нь төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл, 733.5 сая төгрөг нь орон нутгийн өмчит газруудын дансны үлдэгдэл байна.

*Хүснэгт №3. Төрийн сангийн мөнгөн хөрөнгө*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	/сая төгрөгөөр/ Дүнд эзлэх хувь
<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	<b>9,256.90</b>	<b>7,875.37</b>	<b>(1,381.53)</b>	<b>100</b>
Төрийн сангийн харилцах	7,525.00	7,141.86	(383.14)	90.7
Арилжааны банк дахь харилцах	1,731.90	733.51	(998.39)	9.3
<b>Дүн</b>	<b>9,256.90</b>	<b>7,875.37</b>	<b>(1,381.53)</b>	<b>100</b>

*Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ТЭЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн нийт үлдэгдлийн 90.7 хувийг төрийн сангийн, 9.3 хувийн арилжааны банкны харилцахын үлдэгдэл эзэлж байна.

Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 7,141.8 сая төгрөгийн 2,111.0 сая төгрөг нь орон нутгийн төсвийн ерөнхий орлогын дансны, 3,160.4 сая төгрөг нь ОНХС-ийн, 1,147.5 сая төгрөг нь Хоршоо хөгжүүлэх сангийн, 203.8 сая төгрөг нь Замын сангийн, 509.8 сая төгрөг нь Хөрөнгө оруулалтын барьцаа дансны үлдэгдэл, 9.3 сая төгрөг нь төсөвт байгууллагуудын дансны үлдэгдэл байна.

Арилжааны банк дахь харилцах мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 733.5 сая төгрөг нь 3 ОНӨААН болон 1 сумын ЭЭС-гийн дансны үлдэгдэл байна.

Аудитын илрүүлэлт:

*ТЭЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар мөнгөн хөрөнгийн данстай холбоотой зөрчил илрээгүй байна.*

#### 4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 7,469.4 сая төгрөг болж, өмнөх оноос 700.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Өмнөх онтой харьцуулахад ажиллагсадтай холбогдсон авлага 16.2 сая төгрөгөөр, зээлийн хүүгийн авлага 9.2 сая төгрөгөөр, орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын татвар, НДШ-ийн авлага 312.9 сая төгрөгөөр, байгууллагаас авах авлага 57.1 сая төгрөгөөр, хувь хүмүүсээс авах авлага 41.9 сая төгрөгөөр, зээлийн авлага 563.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн дүнтэй байна.

Хүснэгт №4. Авлагын үлдэгдэл төрлөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажиллагчтай холбогдсон авлага	43.24	59.42	16.18	0.80
Төлбөртэй үйлчилгээний авлага	669.74	369.13	-300.61	4.94
Татаас, санхүүжилтийн авлага			0	0.00
Зээлийн хүүгийн авлага	49.57	58.84	9.27	0.79
Дансны авлага /ТӨҮГ/			0	0.00
Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/		312.93	312.93	4.19
<b>Бусад авлага</b>	<b>3,104.13</b>	<b>3,203.09</b>	98.96	42.88
Байгууллагаас авах авлага	3,059.92	3,117.02	57.1	41.73
Хувь хүмүүсээс авах авлага	44.21	86.07	41.86	1.15
<b>Зээлийн авлага</b>	<b>2,902.46</b>	<b>3,466.04</b>	563.58	46.40
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	250.4	250.4	0	3.35
Хувь хүмүүст олгосон зээл	2,652.06	3,215.64	563.58	43.05
<b>Дүн</b>	<b>6,769.14</b>	<b>7,469.45</b>	<b>700.31</b>	<b>100.00</b>
<b>Үүнээс, байгууллагын төрлөөр</b>				
Төрийн сан	856.11	853.14	-2.97	11.42
Төсөвт байгууллага	1,812.59	2,198.07	385.48	29.43
ОНӨҮГ	3,091.68	3,197.34	105.66	42.81
Төсөл/ сан	1,008.76	1,220.90	212.14	16.35
<b>Дүн</b>	<b>6,769.14</b>	<b>7,469.45</b>	<b>700.31</b>	<b>100.00</b>

Эх сурвалж: Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Татвар, НДШ-ийн авлагын 312.9 сая төгрөгийг Цахилгаан шугам сүлжээний газрын татвар, НДШ-ийн авлага эзэлж байна. Байгууллагаас авах авлагын үлдэгдэл нэмэгдэхэд Цахилгаан шугам сүлжээний газрын авлага 51.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Өрхийн эмнэлгүүдийн авлага 258.3 сая төгрөгөөр, “Суат” ХХК- ны авлага 45.8 сая төгрөгөөр, Алтай сумын эргэлтийн эмийн сангийн авлага 0.4 сая төгрөгөөр буурсан нь төлбөртэй үйлчилгээний авлага 300.6 сая төгрөгөөр буурахад нөлөөлжээ. Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон авлагын дүн 250.4 сая төгрөгийн авлагын үлдэгдэлд өөрчлөлт ороогүй байна.

Аймгийн ТЕЗ-ийн байгууллагын төрлөөрх санхүүгийн тайлангийн үзүүлэлтээр нийт авлагын үлдэгдлийн 11.4 хувь буюу 853.2 сая төгрөгийг төрийн сангийн, 29.4 хувь буюу 2,198.1 сая төгрөгийг төсөвт байгууллагын, 42.8 хувь буюу 3,197.3 сая төгрөгийг аж ахуйн нэгжийн, 16.4 хувь буюу 1,220.9 сая төгрөгийг төсөл, сангийн авлага эзэлж байна.

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд  
хийсэн аудитын тайлан

Төсөл сангийн авлага буюу зээлийн авлага бодит байдлаар 3,215.6 сая төгрөг байгаа боловч 1220.9 сая төгрөг нь төсөл сангийн авлагаар бүртгэгдэж, үлдсэн хэсэг нь төсөвт байгууллагын авлагын үлдэгдлээр буруу тайлагнасныг залруулж ажиллахыг зөвлөмж болгов.

Сумуудын хоршоо хөгжүүлэх сангаас хувь хүмүүст олгосон зээлийн авлага өмнөх оноос 563.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

*Хүснэгт №5. Авлагын үлдэгдэл сумаар*

<i>/сая төгрөгөөр/</i>					
Д/Д	Сумын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
1	Алтай	162.0	220.0	58.0	6.84
2	Алтанцөгц	111.1	171.6	60.5	5.34
3	Баяннуур	238.1	199.2	-38.9	6.19
4	Бугат	107.3	122.7	15.4	3.82
5	Булган	169.7	170.3	0.6	5.30
6	Буянт	151.2	137.2	-14.0	4.27
7	Дэлүүн	94.4	260.1	165.7	8.09
8	Ногооннуур	163.6	107.2	-56.4	3.33
9	Сагсай	157.2	227.6	70.4	7.08
10	Толбо	142.2	129.5	-12.7	4.03
11	Улаанхус	221.1	392.3	171.2	12.20
12	Цэнгэл	350.8	287.4	-63.4	8.94
13	Өлгий	583.4	790.4	207.0	24.58
<b>Нийт</b>		<b>2652.1</b>	<b>3215.5</b>	<b>563.4</b>	<b>100.00</b>

*Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ТЭЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Хувь хүмүүст олгосон зээлийн авлагын дүн нийт дүнгээр 563.4 сая төгрөгөөр нэмэгдэхэд Алтай, Алтанцөгц, Бугат, Булган, Дэлүүн, Сагсай, Улаанхус, Өлгий сумуудын зээлийн авлага 0.6-207.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн. Баяннуур, Буянт, Ногооннуур, Толбо, Цэнгэл сумуудын зээлийн авлага 14.0-63.4 сая төгрөгөөр буурсан нь нэмж зээл олгоогүй, зээлийн эргэн төлөлт нэмэгдсэнтэй холбоотой байна.

**Аудитын илрүүлэлт:** Цэнгэл сумын Хоршоо хөгжүүлэх сан хугацаа хэтэрсэн 37.3 сая төгрөгийн найдваргүй зээлийн авлагыг шийдвэрлэж ажиллаагүй байна.

### 4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 14.4 сая төгрөг болж, өмнөх оноос 29.7 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №6. Урьдчилгаа дансны үлдэгдэл*

<i>/сая төгрөгөөр/</i>				
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ТӨҮГ болон ОНӨҮГ	31.1	13.4	(17.70)	93.0
Төсөвт байгууллага	13.0	1.0	(12.00)	7.0
<b>Дүн</b>	<b>44.1</b>	<b>14.4</b>	<b>(29.7)</b>	<b>100</b>

*Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ТЭЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

“Суат” ХХК урьдчилгаа дансанд өмнөх онуудад 13.4 сая төгрөгийн төслийн хөрөнгөөр хийсэн ажлын өртгийг урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн нь барагдаагүй, Дэлүүн сумын ЗДТГ-ын 1.0 сая төгрөгийн урьдчилж гарсан зардал шинээр нэмэгдсэн нь тус сумын тухай цуврал нэвтрүүлэг хийлгэхээр “Хөх тэнгэрийн эсгий туургатан” ХХК-д гэрээ хийж урьдчилгаа олгосонтой холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар урьдчилгаа данстай холбоотой зөрчил гараагүй байна.

#### 4.4 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын дансны оны эцсийн үлдэгдэл 4,726.0 сая төгрөг болж, оны эхнээс 2,134.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7. Бараа материалын үлдэгдэл төрлөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төсөвт байгууллага	1,428.60	1,510.90	82.30	31.97
Төсөл/ сан				
ОНӨҮГ	1,163.10	3,215.10	2,052.00	68.03
<b>Дүн</b>	<b>2,591.70</b>	<b>4,726.00</b>	<b>2,134.30</b>	<b>100.00</b>

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын бараа материалын үлдэгдэл 1,717.8 сая төгрөгөөр, төсөвт байгууллагуудын бараа материалын үлдэгдэл 416.4 сая төгрөгөөр өссөн байна.

#### ХАНГАМЖИЙН БАРАА МАТЕРИАЛ

Хүснэгт №8. Хангамжийн материал төрлөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төсөвт байгууллага	1140.2	1473.3	333.1	69.03
Төсөл/ сан				
ОНӨҮГ	1103.8	660.9	-442.9	30.97
<b>Дүн</b>	<b>2,244.00</b>	<b>2,134.20</b>	<b>-109.8</b>	<b>100</b>

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хангамжийн бараа материалын үлдэгдэл 109.8 сая төгрөгөөр буурсан нь орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын хангамжийн бараа материал буурч, төсөвт байгууллагуудын хангамжийн бараа материалын үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна.

Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын бараа материалын үлдэгдэл буурсан нь Цахилгаан шугам сүлжээний газар “Алтай таван богд, Хилийн 1, 2 заставын чиглэлд цахилгааны шугам татах” төслийг ашиглалтад оруулсантай холбоотой бараа материалын үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна.

Хангамжийн бараа материалын үлдэгдлийн 75.6 хувийг буюу 1,614.6 сая төгрөгийг төсөвт байгууллагуудын, 24.4 хувийг буюу 519.5 сая төгрөгийг орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн материалын үлдэгдэл эзэлж байна.

Тайлант оны эцэст 12.0 сая төгрөгийн бичиг хэргийн, 663.8 сая төгрөгийн аж ахуйн, 503.8 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 112.9 сая төгрөгийн түлш, шатах тослох, 10.1 сая төгрөгийн

барилгын засварын, 1.8 сая төгрөгийн хүнсний, 829.7 сая төгрөгийн бусад хангамжийн материалын үлдэгдэл байна.

### МАЛ АМЬТАД

Мал амьтад дансны үлдэгдэл өмнөх оноос 30.6 сая төгрөгөөр буурч 6.6 сая төгрөгийн үзүүлэлттэй байгаа нь Ногооннуур, Улаанхус сумдын Засаг даргын тамгын газар, аймгийн Байгаль орчны газрын дансанд бүртгэлтэй малын үлдэгдэл буурсантай холбоотой байна.

### Нөөцийн бараа

Нөөцийн бараа дансны үлдэгдэл 172.9 сая төгрөг болж, өмнөх оноос 35.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт №9. Нөөцийн бараа данс байгууллагын төрлөөр

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/			
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төсөвт байгууллага	137.9	172.9	35.0	100
<b>Дүн</b>	<b>137.9</b>	<b>172.9</b>	<b>35.0</b>	<b>100</b>

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нөөцийн бараа дансанд 172.9 сая төгрөгийн аймаг, сумын ОНХС-гийн хөрөнгөөр бэлтгэсэн 5 сумын өвс, тэжээлийн нөөц, 15.3 сая төгрөгийн аймгийн ОНӨГ-ын дансанд бүртгэлтэй цэцэрлэгүүдэд олгох он дамжсан бараа материалын үлдэгдэл байна.

#### Аудитын илрүүлэлт:

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар бараа материалын данстай холбоотой 381.6 сая төгрөгийн зөрчил илэрч албан шаардлага, зөвлөмж өгсөн байна. Үүнд:

- Улаанхус сумын засаг даргын тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурал нярвын бараа материалын тайлан гаргаагүй, агуулахын журналыг хангалтгүй хөтөлсөн.
- Баяннуур сумын засаг даргын тамгын газар 35.4 сая төгрөгийн өвс, тэжээлийн тооцоог баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй.
- Аймгийн Засаг даргын тамгын газар 118.9 сая төгрөгийн бараа материалын тооллого хийгээгүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй.
- Байгаль орчин, аялал жуулчлалын газар 216.7 сая төгрөгийн бараа материалын тооллого хийсэн боловч тооллогын бүртгэл хөтлөлт, баримтжуулалт хангалтгүй, хөрөнгийн тооллогын илтгэх хуудаст бараа материалын тооллогын дүнгийн талаар дурьдаагүй.
- Худалдан авах ажиллагааны газар 10.6 сая төгрөгийн бараа материалын тайлан ирүүлээгүй, НББ-ийг хангалтгүй хэрэгжүүлсэн.

### 4.5 ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 134,588.2 сая төгрөг болж, өмнөх оноос 9,225.7 сая төгрөгөөр өссөн байна.

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

*Хүснэгт №10. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	<i>/сая төгрөгөөр/</i>	
			Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Биет хөрөнгө	116,616.50	125,777.80	9,161.30	93.45
Биет бус хөрөнгө	8,746.10	8,810.40	64.30	6.55
<b>Дүн</b>	<b>125,362.60</b>	<b>134,588.20</b>	<b>9,225.60</b>	<b>100.00</b>
Үүнээс, байгууллагын төрлөөр				
Төсөвт байгууллага	107,642.10	107,386.60	-255.50	79.79
Төсөл/ сан	0.3		-0.3	
Төрийн сан			0	
ТӨҮГ болон ОНӨҮГ	17,720.20	27,201.60	9,481.4	20.21
<b>Дүн</b>	<b>125,362.50</b>	<b>134,588.20</b>	<b>9,225.70</b>	<b>100.00</b>

*Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ТЭЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Нийт үндсэн хөрөнгийн 79.8 хувийг төсөвт байгууллагын, 20.2 хувийг орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн үндсэн хөрөнгө эзэлж байна.

Төсвийн хөрөнгөөр 710.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж, хандиваар 745.6 сая төгрөгийн, үнэ төлбөргүй 654.2 сая төгрөгийн, бусад эх үүсвэрээс 17,373.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хүлээн авч, 654.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авч, дахин үнэлгээний нэмэгдлээр 26.9 сая төгрөгийн, бүгд 19,511.1 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдсэн ба акталсан 1,016.2 сая төгрөгийн, балансаас баланст шилжүүлсэн 655.7 сая төгрөгийн, бусад 35.2 сая төгрөгийн, дахин үнэлгээний хорогдлоор бууруулсан 49.4 сая төгрөгийн, бүгд 1,758.2 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө буурсан байна. Үндсэн хөрөнгөд нийтдээ 9,715.8 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

**Дуусаагүй барилга байгууламжийн талаар:**

Дуусаагүй барилга дансанд 3,399.8 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй ба өөрчлөлт ороогүй байна.

Орон нутгийн өмчийн газрын дансанд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд хийгдсэн 3,229.8 сая төгрөгийн төсөвт өртөгтнй “1000, 900 айлын орон сууцны инженерийн шугам сүлжээ” барилга, байгууламж, Асрамжийн газрын 170.0 сая төгрөгийн барилга бүртгэлтэй байна. Энэ нь улсын комисс хүлээж аваагүй байгаатай холбоотой байна.

“1000, 900 айлын орон сууцны инженерийн шугам сүлжээ” байгууламж аймгийн ОНӨГ-ын дуусаагүй барилга байгууламж дансанд 2023 онд бүртгэгдсэн ба эзэмшигч, ашиглагч байгууллага тодорхойгүй учраас ТӨБЗГ-т 2024 онд Өлгий сумын ЗДТГ-ын дансанд шилжүүлэх саналыг хүргүүлсэн боловч хариу ирээгүй байна.

**Аудитын илрүүлэлт:**

*ТЭЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар үндсэн хөрөнгийн данстай холбоотой 868.5 сая төгрөгийн зөрчил илэрч албан шаардлага, зөвлөмж өгсөн байна. Үүнд:*

- *Бугат сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал 14.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдлийн тооллого хийгдээгүй.*
- *Цагааннуур тосгоны Захирагчийн ажлын алба 594.5 сая төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгийг акталж данснаас хасах арга хэмжээ аваагүй, жилийн эцсийн 170.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг*

*бүрэн хийгээгүй.*

- *Худалдан авах ажиллагааны газар 89.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн тайлан ирүүлээгүй, НББ-ийг хангалтгүй хэрэгжүүлсэн.*

#### 4.6 ӨР ТӨЛБӨР

Нийт өр төлбөрийн үлдэгдэл 12,960.6 сая төгрөг болж өмнөх оноос 3,663.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Өр төлбөрийн 80.3 хувийг богино хугацаат өр төлбөр, 19.7 хувийг урт хугацаат өр төлбөр эзэлж байна. Нийт өр төлбөрийн 42.3 хувийг орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн, 57.7 хувийг төсөвт байгууллагуудын өр төлбөр эзэлж байна.

*Хүснэгт №11. Нийт өр, төлбөр дансны ангилал, байгууллагын төрлөөр*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>6,728.57</b>	<b>10,401.86</b>	<b>3,673.29</b>	<b>80.3</b>
Богино хугацаат зээлийн өглөг	568.84	568.84	0.00	4.4
Өглөг	6,159.73	9,833.02	3,673.29	75.9
<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,568.81</b>	<b>2,558.81</b>	<b>-10.00</b>	<b>19.7</b>
Урт хугацаат зээл	2,568.81	2,558.81	-10.00	19.7
<b>Дүн</b>	<b>9,297.38</b>	<b>12,960.67</b>	<b>3,663.29</b>	<b>100.0</b>
ОНӨҮГазар	4,929.70	5,481.65	551.95	42.3
Төрийн сан	1.5	1.8	0.30	0.0
Төсөвт байгууллага	4,366.18	7,477.22	3,111.04	57.7
<b>Дүн</b>	<b>9,297.38</b>	<b>12,960.67</b>	<b>3,663.29</b>	<b>100.0</b>

*Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ТЭЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Орон нутгийн төсөл сангуудын өглөг 2086.5 сая төгрөгөөр, орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагуудын өглөг 615.0 сая төгрөгөөр, улсын төсвийн байгууллагуудын тогтмол зардлын өглөг 288.8 сая төгрөгөөр, орон нутгийн төсөвт байгууллагуудын өглөг 683.0 сая төгрөгөөр нэмэгджээ. Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгууллагын урт хугацаат өглөг 10.0 сая төгрөгөөр буурсан байна.

#### БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 10,401.9 сая төгрөг болж өмнөх оноос 3,673.3 сая төгрөгөөр нэмэгдсэн. Богино хугацаат өр төлбөрийн 5.5 хувийг буюу 568.8 сая төгрөгийг богино хугацаат зээлийн өглөг, 94.5 хувийг буюу 9,833.0 төгрөгийг бусад өглөг эзэлж байна.

*Хүснэгт №12. Нийт өр, төлбөр дансны ангилал, байгууллагын төрлөөр*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбогдсон өглөг	190.02	307.36	117.34	3.13
Бараа үйлчилгээний зардлын өглөг	186.82	347.48	160.66	3.53
Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг			0	0.00
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	1,029.37	2,149.66	1120.29	21.86

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд  
хийсэн аудитын тайлан

Зээлийн хүүгийн өглөг	33.9	33.9	0	0.34
Байгууллагад төлөх өглөг	4,641.06	6,700.54	2059.48	68.14
Хувь хүмүүст төлөх өглөг	51.33	232.73	181.4	2.37
Татварын өглөг /ТӨҮГ/	24.57	38.06	13.49	0.39
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	2.67	10.19	7.52	0.10
Дансны өглөг /ТӨҮГ/	-	13.1	13.1	0.13
<b>Дүн</b>	<b>6,159.74</b>	<b>9,833.02</b>	<b>3673.28</b>	<b>100.00</b>

*Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Өглөг дансны үлдэгдэл өмнөх оноос 3,673.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь ажилчидтай холбогдсон өглөг 117.3 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний зардлын өглөг 160.6 сая төгрөгөөр, хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг 1,120.3 сая төгрөгөөр, байгууллагад төлөх өглөг 2,059.4 сая төгрөгөөр, хувь хүмүүст төлөх өглөг 181.4, орон нутгийн өмчийн үйлдвэрийн газрын татварын өглөг 13.5 сая төгрөгөөр, НДШ-ийн өглөг 7.5 сая төгрөгөөр, дансны өглөг 13.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Сангийн яам улсын төсвийн орлого бүрдүүлэлттэй уялдуулан оны сүүлийн саруудад хөрөнгө оруулалтын санхүүжилтийг хязгаарласнаас Орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн хөрөнгө оруулалт, замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний өглөг 4,827.9 сая төгрөг болж өмнөх оноос 2,086.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь өр төлбөр нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын өр төлбөр 2,087.2 сая төгрөг болж өнгөрсөн оноос 615.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд: ЦШСГ-ын өглөг 604.8 сая төгрөгөөр, “Хала-Өркени” ОНӨААТҮГ-ын өглөг 26.2 сая төгрөгөөр нэмэгдэж, Суат” ХХК-ны өглөг 16.0 сая төгрөгөөр буурсан байна.

ЦШСГ-ын “Алтай таван богд, Хилийн цэргийн 1, 2 дугаар застав чиглэлийн цахилгааны шугам татах” төслийг ашиглалтад оруулахтай холбоотой үндсэн үйл ажиллагааны орлогоос төслийн ажиллагаанд зарцуулснаас жилийн эцэст “Баруун бүсийн Эрчим хүчний систем” ТӨХК-д өглөгтэй гарсан, “Хала-Өркени” ОНӨААТҮГ цалин, НДШ, татвар, бусад үйл ажиллагааны өглөгтэй гарсан нь өглөг нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, эрүүл мэнд, соёлын байгууллагуудын тогтмол зардлын өглөг 288.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Орон нутгийн төсөвт байгууллагуудын өглөг 683.0 сая төгрөгөөр нэмэгджээ. Үүнд: Сумдын ИТХ-ын өглөг 53.0 сая төгрөгөөр, аймаг, сумдын ЗДТГ-ын өглөг 346.4 сая төгрөгөөр, бусад төсөвт байгууллагуудын өглөг 291.0 сая төгрөгөөр нэмэгдэж, сумын эргэлтийн эмийн сангийн өглөг 7.5 сая төгрөгөөр буурсан байна.

Бусад төсөвт байгууллагуудын өглөг 291.0 сая төгрөгөөр нэмэгдсэнд Хот тохижуулах албаны 207.2 сая төгрөг өглөг нөлөөлсөн байна.

### УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 2,558.8 сая төгрөг болж өмнөх оноос 10.0 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №13. Урт хугацаат өр төлбөр байгууллагаар*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

"Суат" ХХК ОНӨААТҮГ	422.2	422.2	0	16.50
ЦШСГазар ОНӨААТҮГ	2,136.60	2,136.60	0	83.50
Хала-Өркени ОНӨААТҮГ	10.0	0	-10.0	0.00
<b>Дүн</b>	<b>2,568.80</b>	<b>2,558.80</b>	<b>-10.0</b>	<b>100.00</b>

*Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

“Суат” ХХК, ЦШСГ-ын урт хугацаат зээлийн үлдэгдэлд өөрчлөлт ороогүй байна. Сангийн яам “Суат” ХХК-ний урт хугацаат зээлийн төлбөрийг аймагт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс жил бүр хэсэгчлэн төлүүлж байгаа бөгөөд энэ хэмжээгээр урт хугацаат зээлийг бууруулж, богино хугацаат зээлд шилжүүлэн бүртгэсэн ба аймгийн төрийн санд төлөх ёстой өр төлөгдөөгүй байна.

Цахилгаан шугам сүлжээний газарт Дэлхийн банкны “Цахилгааны шугамын шинэчлэл, алдагдал бууруулах” хөнгөлөлттэй зээлийн төслөөр 2009 онд хийгдсэн урт хугацаат хөрөнгө оруулалтын 2,136.6 сая төгрөгийн зээл бүртгэлтэй бөгөөд өр төлбөр дансны үлдэгдэлд өөрчлөлт ороогүй байна. “Хала-Өркени” ОНӨААТҮГ-ын Өлгий сумын Сум хөгжүүлэх санд төлөх 10.0 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Улаанхус сумын засаг даргын тамгын газар урьд оны халаалтын өглөгийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж харуулаагүй орхигдуулж, халаалтын зардалд гэрээнд тусгагдсан дүнгээс 4.6 сая төгрөгийг илүү шилжүүлсэн.
- Цагааннуур тосгоны Захирагчийн ажлын алба 6.8 сая өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй.

